



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



Дархан

2019 он

## Агуулга

### I.Оршил

I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

I.2.Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь

### II.Мал аж ахуй

II.1.Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

- Малтай өрх, малчин өрхийн тооны өөрчлөлт
- Малчдын тоо, нас, хүйсийн бүтэц
- Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

II.2.Малын тоо, бүтэц

- Нийт малын тоо
- Иргэдийн хувийн малын тоо
- Хээлтэгч мал
- Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо
- Төл бойжилт
- Том малын зүй бус хорогдол
- Хүнсний хэрэглээ

### III.Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

- Бэлчээрийн хүрэлцээ
- Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж

### IV.Тэжээвэр амьтад

### V.Газар тариалангийн үйлдвэрлэл

### ДҮГНЭЛТ

Судалгааны хамрах хүрээ

Мэдээллийн эх үүсвэр

Хавсралт

## ОРШИЛ

### **Судалгааны зорилго:**

Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

### **Судалгааны агуулга:**

Судалгааг хөдөө аж ахуйн 2 дэд салбараар хийж, дэд салбар бүрт 2018 оны ерөнхий байдлыг судалж, өсөлт өөрчлөлт, хувь хэмжээг тодрхойлохыг зорив.

Мал аж ахуйн салбарын хувьд малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, тэжээвэр амьтад, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойллоо.

Газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, 1 га-ийн ургац зэргийг өмнөх онтой харьцуулан судалж, гадны аймагт тариалсан талбай болон ургацын хэмжээг тооцож, аймгийн дүнд эзлэх хувь хэмжээ тогтоов.

### I.1.Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

**Малтай өрх.** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

#### **Бодод шилжүүлэх коэффициент:**

1 адуу, үхэр -1 бод

1 тэмээ -1.5 бод

6 хонь – 1 бод

8 ямаа -1 бод Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

#### **Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:**

1тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

**Нас гүйцсэн мал.** Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр -2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал- тухайн жилийн төл малаас бусад насны мал

**Өсвөр насны мал**

Тэмээ –өмнөх оны төл 2,3 настай

Адуу-Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Малын тоо, толгойн өсөлт.** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **Орлого тал** нь төл бойжилт, **Зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

**Төллөлтийн хувь.** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлэн тооцно.

**Бойжилтын хувь.** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

**1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:**

Буур 20-25

Азарга 12-15

Бух 35-45

Хуц, Ухна 25-30

**Том малын зүй бус хорогдолд** Өвчний /халдвартай, халдваргүй/ хорогдол, гэнэтийн аюулын /Цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг / хорогдол, бусад шалтгааны /малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан/ хорогдлыг хамруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь** 3үй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Малын хэрэглээний зарлага** Оны эхний малын тоо дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

**Малын хашааны хангамж.** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

**Тэжээл хангамж** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилүүлж тэжээлийн хамгамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45

Таримал тэжээл -0.35

Даршны ургамал -0.25

Гар тэжээл хужир шүү -1.00

Төмс ногооны хаягдал 0.22

Үр тарианы хаягдал 0.90

Лай -0.40

Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл –өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл –үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл –Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
  - Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил орно.
  - Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Тариалангийн талбай** Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай.** Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Хураасан талбай.** Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ

**Га-гийн ургац** Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын / хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлоно.

**Нийт ургац** Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Нэг га: 10000 м<sup>2</sup> талбайг хэлнэ.

Нэг центнер: 100 кг-тай тэнцэнэ.

Нэг тонн: 1000 кг – тай тэнцэнэ.

## **I.2.ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

2018 онд цаг агаарын байдал олон жилийн дундажтай ойролцоо, мал төллөлт 80.7 хувь, төл бойжилт 99.6 хувьтай болж, мал тооллогын дүнгээр 306014 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 4925 толгой малаар буюу 1.6 хувиар буурсан.


Аймгийн ДНБ болон ХАА-н салбарын эзлэх хувь хэмжээ /сая.төг/

Хүснэгт1

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						%	зөрүү
Бүгд	305144.0	362087.7	367262.7	387260.4	437804.2	113.1	50543.8
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	38143.0	42364.3	35991.7	37564.3	34148.7	90.9	-3415.8
ДНБ-ний дүндээ эзлэх хувь	12.5	11.7	9.8	9.7	7.8	-	-1.9

Зураг1

**ХАА, ойн аж ахуй, ан агнуур /сая.төг/ ДНБ-ний дүндээ эзлэх хувь 2015-2017**



**II.МАЛ АЖ АХУЙ**

**II.1 БҮЛЭГ:МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙНҮЗҮҮЛЭЛТҮҮД**


Малтай өрх, малчин өрхийн тооны өөрчлөлт

2018 онд 2531 малтай өрх үүнээс 1371 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж үүнд 2293 малчид ажиллаж байна.

### Хүснэгт 1: Өрхийн тоо

	2017	2018
Малтай өрх	2531	2366
Малчин өрх	1371	1257
Нэг өрхөд ногдох малын тоо		
Малтай өрх	122	128
Малчин өрх	196	205

### Зураг 1. Өрхийн тоон өөрчлөлт



Энэ графикаас харахад 2014, 2015 оноос малтай өрхийн тоо 2018 онд өсч, 2016, 2017 оноос малтай өрхийн тоо 2018 онд буурсан байна. Малтай өрх өмнөх оноос 165-аар, малчин өрхийн тоо 114 –өөр, малчдын тоо 449-өөр буурчээ.

Аймгийн нийт өрхийн 7.8 хувь нь малтай өрх бөгөөд энэ нь 2017 оноос 0.6 пунктээр бага байна.

### Малчдын тоо, нас, хүйсийн бүтэц

### Хүснэгт 2. Малчдын тоо, нас, хүйсийн бүтэц


	2017	2018
Малчдын тоо	1846	2293

16-34 насны	443	586
35-60 насны	1085	1298
Тэтгэврийн насны	318	409
Нийт малчдаас эмэгтэй	687	985
Насны бүтцээр, хувиар	100	100
16-34 насны	24.0	25.6
35-60 насны	58.8	56.6
Тэтгэврийн насны	17.2	17.8

#### Малчдын тоо, насны бүлэг, бүтцээр

Малчдын 43.0 хувь нь эмэгтэйчүүд ба нийт малчдын 25.6 хувь нь 16-34 насны, 56.6 хувь нь 35-60 насны, 17.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Өмнөх оноос 35-60 хүртэлх насны малчдын нийт дүнд эзлэх хувийн жин 2.2 пунктээр буурч, 16-34 насныхан 1.6 пунктээр, 60 ба түүнээс дээш насныхан 0.6 пунктээр нэмэгдсэн байна.

#### Малчдын соёл ахуйн үзүүлэлт




2018 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор малчин өрхийн 75.3 хувь цахилгааны эх үүсвэртэй, 62.0 хувь нь телевизортой, 79.6 хувь нь автомашинтай, 27.4 хувь нь мотоциклтой, 17.0 хувь нь трактортой байна.

Хүснэгт 3. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт

	Өрхийн тоо		Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	2017	2018	2017	2018
Цахилгаантай	1068	947	77.9	75.3
Телевизортой	975	779	71.1	62.0
Автомашинтай	894	1000	65.2	79.6
Мотоцикльтой	312	345	22.8	27.4
Трактортой	215	214	15.7	17.0

Зураг 2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт



Өмнөх оноос автомашинтай өрхийн тоо 11.9 хувиар, мотоцикльтой 10.6 хувиар тус тус нэмэгдсэн, цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо 11.3 хувиар, телевизортой 20.1 хувиар, трактортой 0.5 хувиар тус тус буурсан байна.

## II.2.МАЛЫН ТОО, БҮТЭЦ


### Нийт малын тоо

Тайлант хугацааны эцэст 306.0 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 1.6 хувиар бага байна. Өмнөх оноос тэмээ 17 толгойгоор, адуу 668 толгойгоор, ямаа 4197 толгойгоор тус тус нэмэгдэж, үхэр 6032 толгойгоор, хонь 3775 толгойгоор тус тус багасчээ.

### Хүснэгт 4. Малын тоо, толгой

	2017	2018	2018/2017%
<b>ДҮН</b>	<b>310939</b>	<b>306014</b>	<b>98.4</b>
Тэмээ	38	55	144.7
Адуу	16996	17664	103.9
Үхэр	50291	44259	88.0
Хонь	150838	147063	97.5
Ямаа	92776	96973	104.5

Зураг 3. Малын тоо, төрөл, бүтцээр, 2018 он



Нийт малын 0.02 хувь нь тэмээ, 5.7 хувь нь адуу, 14.5 хувь нь үхэр, 48.1 хувь нь хонь, 31.68 хувь нь ямаа байна.

**Иргэдийн хувийн малын тоо**


302.1 мянган толгой 98.7 хувь нь иргэдийн хувийн, бусад нь аж ахуйн нэгж, байгууллагын мал байна.

**Хүснэгт 5. Хувийн малтай өрх, малын тоо**

	Малтай өрхийн тоо	БҮГД					
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2017	2531	307254	38	16688	49889	148642	91997
2018	2366	302079	55	17424	43948	144641	96011

2018 онд иргэдийн хувийн малын тоо 302.1 мянган толгойд хүрч, нийт мал сүргийн 98.7 хувийг эзэлж байна. Дундажаар малтай нэг өрхөд 128 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 7 толгойгоор их байна.

**Зураг 4. Хувийн малын тоо, мянган толгой**




Иргэдийн малын тоо толгой өмнөх оноос 1.7 хувиар буюу 5.2 мянган

толгойгоор буурсанаас хонь 2.7 хувиар буюу 4001 толгойгоор, үхэр 11.9 хувиар буюу 5941 толгойгоор буурч, тэмээ 44.7 хувиар буюу 17 толгойгоор, адуу 4.4 хувиар буюу 736 толгойгоор, ямаа 4.4 хувиар буюу 4014 толгойгоор нэмэгджээ. Графикаас харахад иргэдийн хувийн малын тоо 2016 оноос хойш 2 жил дараалан буурсан байна.

Иргэдийн малыг бүлэглэвэл 10-100 толгой малтай нэг өрхөд дундажаар 25, 101-200 малтай нэг өрхөд 143, 201-500 малтай нэг өрхөд 316, 501-999 малтай нэг өрхөд 672, 1000-1499 малтай өрхөд 1109, 1500-2000 малтай өрхөд 1547 толгой мал ногдож байна. Мянгаас дээш толгой малтай 22 өрх байна.

Зураг 5. 2018 оны малтай өрх /малын тооны бүлгээр/



Малтай өрхийн 28.8 хувийг 10 хүртэлх толгой малтай өрх, 18.6 хувийг 11-30 толгой малтай өрх, 12.1 хувийг 51-100 толгой малтай өрх, 12.5 хувийг 101-200 толгой малтай өрх эзэлж байгаа нь бусдаасаа өндөр байна.

2017 оноос 1500-2000 толгой малтай өрхийн малын тоо 3.0 мянгаар, 1000-1499 толгой малтай өрхийн малын тоо 0.7 мянгаар, 501-999 толгой малтай өрхийн малын тоо 12.2 мянгаар, 31-50 толгой малтай өрхийн малын тоо 627 толгойгоор өссөн байна.

### Хээлтэгч мал

2018 онд 149.0 мянган хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 2.6 хувиар буюу 4.0 мянган толгойгоор буурсанаас үнээ 10.4 хувиар 2.3 мянган толгойгоор, эм хонь 4.2 хувиар буюу 3.3 мянган толгойгоор тус тус буурч, ингэ 25 хувиар буюу 4 толгойгоор, эм ямаа 3.1 хувиар буюу 1.5 мянган толгойгоор, гүү 2.5 хувиар буюу 150 толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

	2017	2018
<b>ДҮН</b>	<b>152988</b>	<b>149019</b>
Ингэ	16	20
Гүү	5926	6076
Үнээ	22017	19724
Эм хонь	78056	74754
Эм ямаа	46973	48445

Нийт малын 48.7 хувь нь хээлтэгч мал байна.

Малын төрлөөр нь авч үзвэл нийт малын 0.007

хувь нь ингэ, 2.0 хувь нь гүү, 6.4 хувь нь үнээ, 24.4

хувь нь эм хонь, 15.8 хувь нь эм ямаа байна.

### Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

2018 онд 2312 хээлтүүлэгч мал тоологдож, 2017 оноос 7.1 хувиар буюу 153 толгойгоор нэмэгдсэн байна. 2017 оноос бух 4.3 хувиар буюу 18 толгойгоор буурч, азарга 2.8 хувиар буюу 18 толгойгоор, хуц 17.6 хувиар буюу 118 толгойгоор, ухна 8.2 хувиар буюу 35 толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

### Хүснэгт 7. Хээлтүүлэгч малын тоо, толгой

	2017	2018
<b>ДҮН</b>	<b>2159</b>	<b>2312</b>
Буур	1	1
Азарга	645	663
Бух	418	400
Хуц	670	788
Ухна	425	460

Нийт хээлтүүлэгч малын 0.04 хувийг буур, 28.66 хувийг азарга, 17.3 хувийг бух, 34.1 хувийг хуц, 19.9 хувийг ухна эзэлж

байна.

### Хүснэгт 8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Малын төрөл	Үржлийн норм	2017	2018
Ингэ	8-10	16	20
Гүү	12-15	9	9
Үнээ	35-45	52	49
Эм хонь	25-30	116	95
Эм Ямаа	25-30	110	105

Хуц, ухны үржлийн норм 3.2 дахин, буурны үржлийн норм 2 дахин өндөр байхад, азарганы хувьд үржлийн нормоос бага хээлтэгч ногдож, бухны хувьд үржлийн норм 8.8% их байна.

### Төл бойжилт

2018 онд гарсан төлийн 99.6 хувийг буюу 123.1 мянган толгой төл бойжуулжээ.


Хүснэгт 9. Төл бойжилт, төрлөөр, толгой

	2017	2018					
		Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	124836	123624	9	4080	15722	65460	38353
Бойжсон төл	119366	123076	9	4052	15615	65222	38178
Бойжилтын хувь	95.6	99.6	100	99.3	99.3	99.6	99.5

Төл бойжилтын хувь өмнөх оноос 4.0 пунктээр их байна. Гарсан ботго 100 хувь, унага 99.3 хувь, тугал 99.3 хувь хурга 99.6 хувь ишиг 99.5 хувиар бойжжээ.

Хүснэгт 10. 100 эхээс бойжуулсан төл, төрлөөр, толгой

	2017	2018
БҮГД	76	80
Ботго	44	56
Унага	71	68
Тугал	80	71
Хурга	78	83
Ишиг	72	81



Зураг 8. 100 эхээс бойжуулсан төл, толгой

2018 онд аймгийн дундажаар 100 эхээс 80 төл бойжуулсан нь өмнөх оныхоос 4 төлөөр бага байна.

Үүнээс ботго 12, хурга 5 төлөөр их, унага 3, тугал 9, ишиг 9 төлөөр бага бойжуулжээ.

Том малын зүй бүс хорогдол



Оны эхний малын 98.8 хувь нь онд орж, мал онд оролт өмнөх оноос 4.7 пунктээр бага байна.

Хүснэгт 11. Том малын зүй бус хорогдол, төрлөөр, толгой

	2017		2018	
	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь
Бүгд	19075	5.9	3711	1.2
Тэмээ	4	4.2	0	0
Адуу	595	3.5	146	0.9
Үхэр	2374	4.8	1244	2.5
Хонь	9712	6	1403	0.9
Ямаа	6390	6.7	918	1.0

3711 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 80.5 хувиар бууржээ.

Зураг 9. Том малын зүй бус хорогдол, толгой Зураг 10. Оны эхний малд эзлэх хувь



Нийт хорогдсон малын ихэнх нь буюу 62.5 хувь нь бог мал байна.

Хүнсний хэрэглээ

2018 онд оны эхний нийт малын 6.9 хувьтай тэнцэх 21.5 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулжээ. Малыг хэрэглээний зарлага өмнөх оноос 12.7 хувиар буюу 3.1 мянган толгойгоор бага байна.

### Хүснэгт 12. Хүнсний хэрэглээ

	2017	2018
<b>Бүгд</b>	<b>24535</b>	<b>21419</b>
Тэмээ	1	0
Адуу	571	584
Үхэр	3722	3483
Хонь	12376	10707
Ямаа	7865	6645

Нийт хэрэглэсэн малын 2.7 хувь нь адуу, 16.3 хувь нь үхэр, 50.0 хувь нь хонь, 31.0 хувь нь ямаа байна.

### III БҮЛЭГ: МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ

#### Бэлчээрийн хүрэлцээ :

Хонин толгойд шилжүүлснээр малын тоо 623.8 мянга болж, өмнөх оноос 4.8 хувиар буурсан байна. 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 337 байгаа нь 2017 оноос 17 толгойгоор бага байна.

#### Хүснэгт 13. Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2017	2018
Хадлан бэлчээрийн талбай /мянган га/	185.1	185.1
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн малын тоо	655244	623816
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	354	337

#### Малын тэжээл үйлдвэрлэлт, хангамж

Энэ онд 49088.4 тонн өвс, тэжээлийн нэгжид шилжүүлснээр 26925.4 тн тэжээл бэлтгэсэн нь өмнөх оноос 49.6 хувиар их байна.

Хүснэгт 14. Бэлтгэсэн тэжээл нэр төрлөөр, тонн


	2017	2018
Хадлан өвс	33713.8	49088.4
Таримал тэжээл	26.2	321.7
Даршны ургамал	16.5	185.7
Гар тэжээл, хужир шүү	1015.1	2963.5
Үр тарианы хаягдал	1391.1	1741.6
Сүрэл	135.5	343.7
Үйлдвэрлэсэн тэжээл, тн, /тэж.нэгж шилжүүлсэн/	17995.7	26925.4

Хүснэгт 15. Тэжээл хангамж

	2017	2018
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж, нэгж шилжүүлсэн)	17995.7	26925.4
Нийт малыг хонин толгойд шилжүүлэн (мянган толгой)	655.2	623.8
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, (тэж, нэгж кг)	27.5	43.2

2018 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 43.2 кг тэжээл ногдож байгаа нь 2017 оныхоос 15.7 кг-аар нэмэгджээ.

Зураг 11. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, нэгж, кг



#### IV БҮЛЭГ: ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Аймгийн хэмжээнд 1135 гахай, 9530 шувуу, 24 туулай, 2376 бүл зөгий тоологдож, өмнөх оноос гахай 10.2 хувиар, зөгий 380 бүлээр буюу 19.0 хувиар тус тус өсч, шувуу 12.0 хувиар, туулай 11.1 хувиар тус тус багассан байна.

	Тэжээвэр амьтдын тоо	
	2017	2018
Гахай	1030	1135
Шувуу	10831	9530
Зөгий /бүл/	1996	2376
Туулай	27	24

#### V БҮЛЭГ: ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

##### Тариалалт

Хаврын тариалалтаар 11944.6 га-д үр тариа ( үүнээс 11396.6 га-д улаан буудай), 603.3 га-д төмс, 1268.2 га-д хүнсний ногоо, 2503.7 га-д малын тэжээл, 4182.2 га-д рапс тариалжээ. Тариалалт өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар буурчээ.

## Хүснэгт 16. Тариалсан талбайн хэмжээ, га

	2017	2018
Тариалалт эрхэлсэн өрхийн тоо	2491	2021
Нийт тариалсан талбай	22528.1	20502.1
Үр тариа	15064	11944.6
Төмс	874.1	603.3
Хүнсний ногоо	1455.2	1268.2
Тэжээлийн ургамал	90	2503.7
Техникийн ургамал /рапс/	5044.8	4182.2
Жимс, жимсгэнэ	55	59.3

Нийт тариалсан талбайн 58.3 хувь буюу 11.9 мянган га-д үр тариа, 2.9 хувь буюу 603.3 га-д төмс, 6.2 хувь буюу 1.3 мянган га-д хүнсний ногоо, 12.2 хувь буюу 2.5 мянган га-д тэжээлийн ургамал, 20.4 хувь буюу 4.2 га-д техникийн ургамал /рапс/ тариалжээ. Өмнөх оноос нийт тариалсан талбай 9.0 хувь буюу 2026 га-аар буурсан байна.

Ургац хураалт

Намрын ургац хураалтаар

	2017	2018
Хураасан ургац	34246	38971.1
Үр тариа	11201.5	10296.2
Төмс	8605.2	7969.9
Хүнсний ногоо	13665.8	16049.7
Тэжээлийн ургамал	162	3932.5
Техникийн ургамал /рапс/	610.8	722.5

Өмнөх оноос хураасан үр тариа 905.3 тн буюу 8.1 хувиар, хүнсний ногоо 2383.9 тн буюу 17.4 хувиар, тэжээлийн ургамал 3770.5 буюу 24 дахин их, техникийн ургамал 111.7 тн буюу 18.2 хувиар их, төмс 635.3 тн буюу 7.4 хувиар буурсан байна.

Нэг га-аас дунджаар 8.6 цн үр тариа, 132.1 цн төмс, 126.4 цн хүнсний ногоо, 16.0 цн тэжээлийн ургамал, 1.8 цн техникийн ургамал /рапс/ хураан авсан бөгөөд өмнөх оноос үр тариа 1.2 цн, төмс 33.7 цн, хүнсний ногоо 32.5 цн-ээр их байна.

## ДҮГНЭЛТ

Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтээр манай аймаг улсын хэмжээнд харьцангуй бага хувийг эзэлдэг ба энэ нь газар нутаг багатайн дээр аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарт түшиглэсэн хотжилт түлхүү хөгжсөнтэй холбоотой.

### Мал аж ахуй

2018 оны байдлаар аймгийн хэмжээнд 1257 малчин өрх, 1846 малчин мал аж ахуй эрхэлж байна. Өмнөх оноос малчин өрх, малчдын тоо буурчээ.

2018 онд малчин өрхүүд 258.0 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оныхоос 11.2 мянган толгойгоор буюу 4.2 хувиар буурчээ.

Тухайлбал: Малын төрлөөр авч үзвэл тэмээ 53.8 хувь буюу 14 толгойгоор, ямаа 2 хувь буюу 1.6 толгойгоор өсч, адуу 0.9 хувь буюу 134 толгойгоор, үхэр 14.3 хувь буюу 5.5 толгойгоор, хонь 5.4 хувь буюу 7.3 толгойгоор буурчээ.

Том малын зүй бус хорогдол өмнөх оноос 80.5 хувиар буурсан ба нийт хорогдлын 3.9 хувь нь адуу, 33.5 хувь нь үхэр, 37.9 хувь нь хонь, 24.7 хувь ямаа байна.

149.0 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 48.7 хувийг эзэлж, өмнөх оноос хээлтэгчийн тоо 2.6 хувь буюу 4.0 мянган толгойгоор буурчээ.

2018 оны байдлаар 123.1 мянган төл бойжуулсан нь өмнөх оноос 3.1 хувиар буюу 3.7 мянган төлөөр, сувайрсан хээлтэгч 23.3 буюу 3.5 толгойгоор, 100 эхээс бойжуулсан төл 5.3 хувиар буюу 4 толгойгоор тус тус өсч, малын зүй бус хорогдол

80.6 хувиар буюу 15.4 мянган толгойгоор, хээл хаясан хээлтэгч 18.3 буюу 913 толгойгоор, хээлтэгч мал 2.6 хувиар буюу 4.0 толгойгоор буурчээ.

Малын үржлийн нормоор гүүнээс бусад малын төрөл дээр хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна. (хүснэгт 7) Энэ байдал жилийн жилд гардаг үзэгдэл бөгөөд энэ нь мал үржлийн ажлыг бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мал сүргийн 79.7 хувь нь бог мал, бог малын дийлэнхи нь хонин сүрэг, бод малын дийлэнхи нь үхэр сүрэг ба аймгийн малын бүтцэд бог малын эзлэх хувийн жин өсөх хандлага жил бүр хадгалагдаж байна.

### Газар тариалан

Хаврын тариалалтаар 11944,6 га-д үр тариа (үүнээс 11396.6 га-д улаан буудай), 603.3 га-д төмс, 1268.2 га-д хүнсний ногоо тариалжээ. Тариалалт өмнөх оноос 9 хувиар буурчээ.

Намрын ургац хураалтаар 11944.6 га-аас 10296.2 тн үр тариа, 603.3 га-аас 7969.9 тн төмс, 1268.2 га-аас 16049.65 тн хүнсний ногоо хураан авчээ. Хураасан талбайн 1 га-аас 8.6 цн үр тариа, 132.1 цн төмс, 126.4 цн хүнсний ногоо хураасан байна.

Аймагт газар тариалангийн хэмжээ бага, тариалангийн талбай хүрэлцдэггүйгээс хөрш, зэргэлдээ аймгийн газар нутагт тариалалт хийдэг мал аж ахуйн эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих

Хадлан, тэжээл үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

**СУДАЛГААНЫ ХАМРАХ ХУГАЦАА:** 2016-2018 он, зарим график дүрслэлийг 5 жилээр гаргав.

**МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР:**

- 2016-2018 оны жилийн эцсийн мал тооллогын материал
- 2018 оны аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга
- 2017 оны Улсын Статистикийн эмхэтгэл
- Статистикийн шинжилгээ судалгаа хийх арга зүйн зөвлөмж /Аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудад зориулав/

2000-2018 ОНЫ МАЛЫН ТОО, толгой

ОН	НИЙТ МАЛ				
		ДАРХАН	ХОНГОР	ОРХОН	ШАРЫН ГОЛ
2000	194531	69161	49512	36930	38928
2001	166037	49328	63660	32819	33887
2002	179694	49328	63660	32819	33887
2003	122238	43128	30666	19838	28606
2004	125054	45028	29319	21053	29654
2005	142869	35836	50772	24902	31359
2006	180193	49157	61314	29888	39834
2007	230379	66774	72976	41890	48739
2008	345292	102182	124452	61663	56995

2009	361532	107690	135973	56805	61064
2010	249821	75228	103995	33534	37064
2011	256810	70467	113087	36812	36444
2012	268369	79883	125514	25970	37002
2013	279053	75752	129755	37266	36280
2014	324241	69297	172794	41285	40865
2015	288363	61149	150187	37571	39456
2016	324163	72260	167918	41465	42520
2017	310939	68954	163955	40315	37715
2018	306014	68362	165314	41769	30569

2000-2018 ОНЫ ТАРИАЛСАН ТАЛБАЙН, га

	ҮР ТАРИА	ТӨМС	ХҮНСНИЙ НОГОО	ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ	ТЕХНИКИЙН УРГАМАЛ
2000	13553	456.7	595.3	0	0
2001	12861	428.6	619.7	588.0	0
2002	14616	522.5	765.3	0	0
2003	13598	443.5	781.9	20	0
2004	7881	515.9	794.4	0	767
2005	6651	522.6	823.0	987.0	0.1

2006	2470	663.7	747.2	440	6986
2007	2308	654.8	700.3	12.8	7106
2008	4858	801.3	606	12.8	1956
2009	8659	1085.4	600	14.5	1720
2010	6823	960	916.8	208	4798.9
2011	11041.4	1001.8	916.7	230.2	1107.8
2012	9050.9	1189.5	961.6	397.0	3942.0
2013	10640.5	695.0	1240.5	92.5	5775.4
2014	11030.5	591.2	1341.4	319.7	5641.1
2015	14660.9	382.8	1023.6	128.0	4752
2016	11709.7	663.9	1653.2	170	4793.6
2017	15064	874.1	1455.2	90	5044.8
2018	11944.6	603.3	1268.2	2503.7	4122.0

2000-2018 ОНЫ УРГАЦ ХУРААЛТ, ТН

	ҮР ТАРИА	ТӨМС	ХҮНСНИЙ НОГОО	ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ	ТЕХНИКИЙН УРГАМАЛ
2000	7485.5	4348.6	8097.8	0	0
2001	8565.6	4127.9	8073.7	0	0
2002	3906.1	2417.3	4760.8	0	0

2003	10526	3588.1	9456.1	0.3	0
2004	5667.5	4819.8	8183	0	360
2005	1527	2885.9	11982.8	0	496
2006	2461.9	5395.5	10975.5	0	948.3
2007	1748.2	5703.8	9234.8	0	1327.1
2008	4132.6	11166.2	7505.8	20.0	598.0
2009	9642.6	13636.6	7829.6	215.0	557.5
2010	9737.6	13645.6	7829.5	215.0	2398.5
2011	16803.8	14276.5	13144.7	6308.6	473.6
2012	12820.8	14208	12928.9	1600.0	2150.0
2013	11698.0	8418	15277.9	147.9	2370.2
2014	14937	7327.6	17085.8	489.1	3948.1
2015	3794.0	2944.8	4776.0	2088.3	609.6
2016	18918.8	7420.5	14358.8	306.0	1408.0
2017	11030.0	8544.8	13220.6	162.0	610.8
2018	10296.2	7969.9	16049.7	3932.5	722.5

